

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖИЛТИЙГ СУРГАЛТАД АШИГЛАХ НЬ

*Х. Өрнөлт, ӨМБИС*

### Abstract

In this research paper ERLIAN city of People's Republic of China and the current state of tourism of ERLIAN city were all studied. All the facts in this research are based on the information about trade and businesses that depend on the tourism. Highlighting the ways of improving the tourism in the region is the main purpose of this research paper.

Although, there is a limited number of researchers who studied this topic, although many researchers have conducted their studies to popularize tourism.

In the era of globalization, combining economical ideas with the tourism of certain areas is essential. Moreover, doing this operation with the help of scientific reasoning is becoming increasingly a worldwide phenomena.

Based on the practical examples, the issue of developing the tourism and trade in ERLIAN city is not just something that People Republic of China and Mongolia should take care of. It is crucial to develop wide range of policies on international stage and to implement those policies in real life.

Thus, to develop regional tourism on the international stage, the government of that country should take an extra care. In this research paper, issues based on government policy, and a synthetic route to implement those policies in real life are all stated.

### Түлхүүр үг

Хилийн боомт хот, худалдааны аялал жуулчлал, орон нутгийн соёл иргэншлийн онцлог, байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалын хотхон

### Удиртгал

ӨМӨЗО-ны Эрээн хот нь БНХАУ-ын хойт талд оршдог бөгөөд Монгол Улсын Дорноговь аймгийн Замын-Үүдтэй хиллэдэг, хилийн боомт хот болно. Эрээн хот нь Бээжинд хамгийн ойрхон хуурай замын хилийн боомт бодгоороо нэн онцлогтой.

БНХАУ, Монгол Улсын хилийн дагуу 20 шахам боомт байдгаас хамгийн том нь Эрээн хот юм. Өвөр Монголын хувьд авч үзвээс, Монгол улстай болон Ази, Европыг холбож байдаг найрамдал, хамтын ажиллагааны нэгэн том “цонх” хэмээн үзэж болно.

БНХАУ-ын Засгийн газраас анх 1982 онд Оросын Холбооны Улстай хиллэдэг Манжуур хотыг анх “Чөлөөт хот” болгон тунхаглаж байсан бөгөөд улмаар 1992 онд БНХАУ-тай хил залгаа орнуудын арван гурван газрыг “Чөлөөт хот” болгосны нэг нь “Эрээн хот” болно.

Түүнчлэн БНХАУ-ын Засгийн газар 2014 оны 6 дугаар сард тусгай шийдвэрээр Эрээн хотыг Монгол Улстай бүх талаар чөлөө бодлого явуулах “загвар хот” болгосон билээ (БНХАУ-ын Засгийн газрын мэдээ. 2014, х. 28). Энэ нь Монгол Улс, Оросын Холбооны Улстай харилцах олон талын хамтын ажиллагааны төдийгүй, түүхэн уламжлалт “Торгоны зам”-ын харилцааг

сэргээн хөгжүүлэх бодлогод тулгуурласан чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Ийнхүү Эрээн хот нь Олон улсын найрамдал, хамтын ажиллагаа, худалдаа, эдийн засаг, зам харилцаа, соёл, боловсролын “гол түлхүүр” болж, түүхийнхээ 60 жилийн босгыг алхаж, хөгжлийнхөө хэтийн төлөвийг тодорхойлж байна.

#### *Аялал жуулчлалын өнөөгийн байдал*

Эрээн хотын эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт, туйлын хурдтай байгааг судалгаа харуулж байна. 2011-2015 онд тус хотын үндсэн орлого нь 47.6-100 тэрбум юань хүртэл өссөн бөгөөд жилийн орлогын дундаж өсөлт 16 хувь байна.

Эдийн засгийн асар хурдацтай энэхүү өсөлт нь тус хоттой холбоотой аялал жуулчлалын авч салбарыг хөгжих ая таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Зөвхөн сүүлийн таван жилд 2600000 гаруй жуулчныг хүлээн авч, үйлчилсэн нь жуулчдын зорчих жилийн дундаж өсөлт нь 5.1 хувьд хүрчээ. Аялал жуулчлалын салбарын үндсэн орлого сүүлийн 5 жилд 173 тэрбум юаньд хүрсэн нь жил тутамд дунджаар 17.9 хувиар

өссөн байна.

Эрээн хот нь Хятад, Монгол хоёр орны аялал жуулчлалын хил дамжсан “Загвар бүс” болох үндэс сууриа тавьж, хотын бүтээн байгуулалт, аялал жуулчлалын тохилог орчныг бүрдүүлэхээр чармайж байна. Зөвхөн 2015 онд тус хотод 600000 орчим жуулчдыг хүлээн авч үйлчилсэн нь өмнөх оноос 8.5 хувиар өссөн байна. Мөн аялал жуулчлалын үндсэн орлого 2015 онд 40 тэрбум юаньд хүрч, өмнөх жилээс 14.3 хувиар өсжээ. Аялал жуулчлагчдын тоо 2016 оны эхний 7 сард 370000 хүнд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 9.2 хувиар өсжээ. 2016 оны эхний 7 сарын үндсэн орлого 24 тэрбум юаньд хүрсэн нь өмнөх жилийн мөн үеийнхээс 14.6 хувиар өссөн байна (Статистик тайлан, 2016.х. 41).

Жуулчдын бүрэлдэхүүнийг гадаад орны болон улсын дотоодын бүрэлдэхүүнээр авч үзвэл 2016 оны эхний 7 сард дотоодын жуулчид 210000-д хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувь нэмэгдсэн байна. Гадаад орны жуулчид дээрх хугацаанд 160000-д хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 9 хувь нэмэгдсэн байна.

Хөгжлийн дээрх үзүүлэлт нь нэгдүгээрт, Эрээн хотын орчны хөгжил болон үлэг гүрвэлийн зэрэг сонирхолтой үзмэр, хоёрдугаарт, монгол, хятад орны аялал жуулчлалын харилцан ашигтай худалдаа, хамтын ажиллагаанд үндэслэсэн зэрэгтэй холбон тайлбарлаж байна.

Аялал жуулчлалын энэхүү өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа нь Эрээн хотыг хөгжүүлээд зогсохгүй, Эрээний иргэд, ажилчид, малчдын аж амьдралыг хөгжин дэвжих гол хүчин зүйл болж байгаагаараа чухал ач холбогдолтой юм. Тиймээс бид аялал жуулчлалын хичээл заахдаа “Эрээн хот”-ыг загвар болгож дурдаж болох юм.

Эрээн хотын аялал жуулчлалын салбарын хөгжлийн байдлыг судалж үзсэндээ дүгнэлт хийхэд: Нэгдүгээрт, эдийн засаг, хүний тоон үзүүлэлтүүд асар өндөр хурдацтай байна. Хоёрдугаарт, тус хотын аялал жуулчлалын салбарыг жинхэнэ шинжлэх ухааны үүднээс хөгжүүлэх талаас нь авч үзвэл учир дутагдалтай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Цаашид бид:

- Аялал жуулчлалын нэгдсэн бодлого, төлөвлөлт дутагдаж байгааг залруулах;
- Эрээн хотын Захиргаанаас аялал жуулчлалд зориулсан хөрөнгө оруулалт болон орлого, зарлагын бодлогыг жил бүрийн /5 жилийн/ төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлдэг болгох;
- Аялал жуулчлалын салбарын мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ дутмаг;
- Аялал жуулчлагчид зориулсан үйлчилгээний соёл, уламжлал бүхий олон талт, хэлбэрийг буй болгож хэрэгжүүлэх,

- Эрээний аялал жуулчлалын хүрээг Олон Улсын худалдаа, арилжааны харилцаанд суурилж, ӨМӨЗО-ны соёл иргэншил, үзмэр, үйлчилгээ сурталчилгааны шинэ хэлбэрт оруулж, хөгжүүлэх;
- Эрээний бүс нутагт аялал жуулчлалыг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх “Төсөл” боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар, холбогдох яам, газрын шугамаар зохион байгуулах;
- Эрээний аялал жуулчлалын үйл ажиллагааг “Торгоны зам”-ын хөгжлийн бодлоготой уялдуулж, Ази, Европын тивийн холбогдох улс орны хүрээнд зохион явуулах зэрэг болно.

Аялал жуулчлал нь хотын үсрэнгүй хөгжил, соёлын харилцааны гол оньсон түлхүүр болно. Түүнчилэн хот нь аялал жуулчлалыг хөгжүүлэх хүчин зүйл болж, харилцан шүтэлцэлтэйгээр хөгжих зүй тогтолтой юм. Эрээн хот соёл, иргэншлийн өв дурсгалт зүйлийг хадгалагч төв болоод зогсохгүй, худалдаа үйлчилгээний өргөн хүрээтэй систем болон хөгжиж байгаагаараа Дэлхийн Олон Улсын анхаарлыг зүй ёсоор татсаар байна. Иймд хотын хөгжлийг аль болохоор түргэтгэх асуудлыг дээрх зангилаа бүхий хүчин зүйлийг орон нутгийн соёл иргэншлийн онцлогтой харилцан уялдаатайгаар авч үзэж, хэтийн төлөвийг тодорхойлох нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна.

*Эрээн хотын аялал жуулчлалын хөгжлийн нэг гол суурь нь хилийн боомт болох нь*

БНХАУ-ын Засгийн газрын бодлого, ард түмний амьжиргааны гол түшиц газар нь “Эрээн боомт” бөгөөд түүний нэг онцлог нь Олон улс, гадаад орон руу хандсанаар тайлбарлагдаж байдаг юм. Энд ялангуяа хил залгаа Монгол улстай хамааралтайгаар хөгжлийн онцлогийг авч үздэгт түүний бас нэгэн хүчин зүйл оршино. Хотын газар зүйн байршил, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүтээн байгуулалтыг боомтын хөгжлөөс салангид авч үзэх аргагүй юм. Ийнхүү хот, боомт, хүн ардын хөгжлийн асуудлыг харилцан уялдаа, шүтэлцээтэйгээр авч үзэх нь чухал болно.

Эрээн хотын хөгжлийн үндсэн гол үзүүлэлтүүдээр нь авч үзвэл, зөвхөн 2015 онд Хөдөө аж ахуй 0.65 хувь, аж үйлдвэр 35.85 хувь, үйлчилгээний салбар 63.5 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр баримтаас үзэхэд, Эрээн хотын хөгжлийн гол тулгуур нь үйлчилгээний салбар болох нь тодорхой харагдаж байна.

Эрээн хотод аж үйлдвэр төдийлөн хөгжих боломжгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж, Эрээн боомтыг түшиглэн нэгдүгээрт,

үйлчилгээний салбарыг бусдаас түлхүү анхаарч хөгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Энэ нөхцөл байдалд тулгуурлан Эрээн хотод аялал жуулчлалын арилжаа-худалдааг зөвхөн Монгол, Хятад хоёр орны хувьд бус, цаашид Олон улсын хүрээнд өргөн цар хүрээтэй зохион явуулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэн хөгжүүлэх нь зүйтэй юм.

Эрээн хотын байгаль орчин, газар зүйн байршил нь аялал жуулчлалын бүхий л салбарыг хөгжүүлэхэд төдийлөн хангалттай гэж үзэх үндэслэлээр дутмаг гэдгийг энд дурдах нь зүйтэй. ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг болон Үзэмчиний тал нутагт ирсэн жуулчид тэндхийн хөх тэнгэр, цагаан үүл, ногоон тал, хонин сүрэг зэргээс эхлээд үзэж сонирхон ая таашаал авах жишээтэй. Гэтэл Эрээнд ирсэн жуулчид байгаль зэрэг жуулчдыг татах үзүүлэх, ховор сонин зүйл багатай тул тоон нь тогтмол өсөх боломжгүй гэдгийг харуулж байна.

Нөгөөтгээгүүр, Эрээн хотын цаг агаар, уур амьсгалын талаар авч үзвэл:

Сэрүүн бүсийн, хуурай уур амьсгалтай, хаврын улиралд хур бороо байхгүй, элсэн шуурга дэгддэг, зуны улиралд гандуу, бороо хур дутмаг, хэт халуун газар дээр 40 хэм хүртэл халдаг, намрын улиралд эрт хяруу унадаг, өвөлдөө гол төлөв хүйтэрдэг, цас бараг ордоггүй бөгөөд арван жилийн есөн жил нь гантай байдаг. Жилийн дундаж тунадасны хэмжээ 140 мм хүрэхгүй. Энэ нь ӨМӨЗО-ны 300 орчим мм тунадасны дунджаас доогуур байна.

Эрээн хот нь цэвэр усны нөөц байхгүй, 60 км хол газраас ундны усыг татаж авдаг. Энэ нөхцөл байдал нь ус их хэмжээгээр хэрэглэдэг аж үйлдвэрийг Эрээнд хөгжүүлэх боломжийг хязгаарладаг нэгэн дутагдалтай талтай. Иймд Эрээний байгаль орчин хамгаалах асуудал хамгийн тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай зүйл болоод байна.

Эрээн хотын байгаль орчны бэрхшээлтэй онцлог тал нь аялал жуулчлалыг зохих ёсоор өргөн хүрээтэй хөгжүүлэхэд төдийлөн зохимжтой бус болох нь дээрх нөхцөл байдлаар тайлбарлагдана. Гагцхүү Эрээний хилийн боомтын аялал жуулчлалын давуу талыг зохистой бодлогоор хөгжүүлж ажиллах нь улс төр, эдийн засаг, нийгэм соёл боловсролын олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагааны үнэт зүйл нь болох юм.

*Орчин үед зах зээлийн нийгмийн харилцаа нь Эрээн хотын хөгжилтийг тодорхойлж байгаа нь*

Эрээний боомт байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын зах зээлд түшиглэж ирсэн. Боомтын арилжаа нь өнөөдрийн байдлаар Монгол, Хятад хоёр орны худалдааны

харилцааны 60 гаруй хувийг эзэлдэг. Арав гаруй жилийн өмнө Эрээний боомтын арилжаа нь хоёр орны худалдааны харилцааны 90 хувийг эзэлж байжээ. Иймээс “Эрээн боомт” бол Монгол, Хятад, Орос гурван улсын худалдаа арилжаа, хамтын ажиллагааны гол цөм нь юм.

Эрээн хот нь монгол улсын иргэдийг нэгэн татах хүчин болж байдгийг олон баримтаас харж болно. Тухайлбал, Эрээн хотын хилийн боомт чөлөөтэй болсон тэр үеэс өнөөг хүртэл Монголын хүн амын, иргэдийн 70 орчим хувь нь Эрээн боомтоор зорчин өнгөрсөн гэсэн Эрээн хотын Засгийн газрын мэдээ байдаг (Зах зээлийн эдийн засгийн мэдээлэл, 2015, х.18)

Ийнхүү өнөөдрийн байдлаар Монгол орноос олон хүн Эрээн хотод арилжаа худалдаа, сурч боловсрох, тойрон аялал зэрэг чиглэлээр зорчиж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Монголчуудын Эрээн хотыг зорьсон дээрх хөдөлгөөн нь тус хотыг хөгжүүлэх нэмэлт хүчин болж өгч байгаа нь нууц биш юм.

Эрээн хотын Монгол улс руу хандсан хандлага нь Монгол Эрээний хоорондын харьцаанд дэвшлийг бий болгож байгаа хэдий ч Монголын болон дэлхийн эдийн засгийн хямрал сөргөөр нөлөөлөх нь бий.

Эрээнд дээр бидний өгүүлснээр аж үйлдвэр, хөдөө аж ахуй төдийлөн хөгжөөгүй боловч, худалдаа, үйлчилгээний салбар асар хурдан эрчимтэй хөгжсөн нь гагцхүү Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үр дагавраас шууд хамааралтайгаар явж ирснийг дурдах хэрэгтэй. Гадаад улсын хамааралтай, эдийн засгийн тогтвортой бус байдлаас гарахын тулд өөрийн улсын доторх арилжаа худалдааг хөгжүүлэх шаардлагатай бөгөөд үүний дотор дотоодын худалдааны аялал жуулчлалыг өргөнөөр нэвтрүүлэх нь тогтвортой бүс хөгжлийн замаас ангижрах нэг үндэс болох юм.

*Соёлын асар их өв сан нь Эрээн хотын аялал жуулчлалын хөгжлийг тодорхойлох нэг чиглэл болох нь*

Эрээн хот нь орон нутгийн төдийгүй олон үндэстэн ястны соёлын өвийг хадгалж байдгаараа онцлогтой. Тухайлбал, нүүдлийн соёл, газар тариалангийн соёл, Монгол болон Хятад улсын соёл, БНХАУ-д байгаа монгол үндэстний соёл, ӨМӨЗО-ны бүх үндэстэн ястнуудын соёл зэрэг олон асуудлыг энд хамруулан авч үзэж болно. Эдгээр олон соёлын цогцолбор нь Эрээн хотын шинэ эриний боомтын соёлыг бүрдүүлж байгаа билээ.

Аливаа үндэстний соёл нь тухайн орны аялал жуулчлалын сүнс, аялал жуулчлалын хөгжлийн эх булаг юм.

Өнөөгийн Эрээн нь эртний үлэг гүрвэлийн

өлгий нутаг, өртөө замчдын гол орон, адуу, тэмээ маллах соёл, хотын соёл иргэншлийн үзмэрийн төв болдгоороо нэн онцлог билээ.

Түүнчлэн, “Цайны зам”, Замын-Үүдийн нэг хоногийн аялал зэрэг нь Эрэн хотын аялал жуулчлалын нэг гол хүчин болж байна. Гэхдээ 20 шахам жилийн хугацаанд Эрэн хотын аялал жуулчлалын хөгжлийн байдлыг судалж үзэхэд тус хотын аялал жуулчлалын хөгжил нь зөвхөн анхан шатандаа явагдаж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа болно.

Энэ нь Эрэнд аялал жуулчлалын үзмэр, үйлчилгээний нөөц дутагдсандаа биш, харин дээрх нөөц баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, үе шаттайгаар нээн илрүүлж, зохион байгуулалттай ашиглаж амжаагүй байгаатай шууд холбоотой. Энэ үүднээс авч үзвэл тус хотод худалдаа арилжааны аялал жуулчлал илүүтэй хөгжсөн давуу байдалдаа тулгуурлан аялал жуулчлалын бусад салбар, хэлбэрүүдийг хөгжүүлэх нь, аялал жуулчлалыг жинхэнэ ёсоор хөгжүүлэх үндэс суурь нь болно.

## Дүгнэлт

Аливаа оронд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тухайн газар орны аялал жуулчлалыг хөгжүүлэх юуны өмнө жанжин шугамаа тодорхойлох нь чухал юм. Үүнд:

Нэгдүгээрт, соёл иргэншлийн түүхэн онцлогийг нээсэн, жуулчдын анхаарал, сонирхлыг татаж чадах эрхэм зүйлүүдийг тод томруун харуулж гаргах нь өнөөдрийн Засгийн газрын бодлогын хүрээнд шийдвэрлэх нэн чухал асуудал болж байна;

Хоёрдугаарт, Аялал жуулчлалын менежментийг зөвхөн өөрийн оронд төдийгүй, Олон Улсын жуулчлалын түвшинд зохион байгуулж, сурталчлах чадварлаг хүний нөөцийг бэлтгэж буй болгох нь тэргүүн зорилтын нэг юм;

Гуравдугаарт, Боомтын жуулчлалын давуутай талд үндэслэн, Эрэн хотыг “Худалдааны аялал жуулчлалын төв” болгон хөгжүүлэх, үүний тулд зах зээлийн эдийн засгийн хөгжлийн шаардлагын дагуу, бараа бүтээгдэхүүний “чанарын баталгааг” буй болгож, тэдгээрт тавих хяналтыг сайжруулах, орчин үеийн мэдээлэл харилцааны дэвшлийг ашиглаж /онлайн/ Худалдаа, аялал жуулчлалын төвд Монгол болон Европын орнуудын бараа бүтээгдэхүүнийг Бүх Хятад улс даяар борлуулах ажлыг сурталчлан зохион байгуулах;

Дээрх төвд “Олон улсын худалдааны баяр”-ыг жил тутамд зохион байгуулж, Монгол болон бусад орны бүтээгдэхүүнүүдийг бүх Хятад орон даяар худалдаалах ажлыг өргөжүүлж, сурталчлах зохион байгуулалтын арга хэмжээ

авах;

Дөрөвдүгээрт, Эрэн, Замын-Үүдийн хооронд хил дамжсан “Аялал жуулчлалын хотхон” байгуулж, найрамдал хамтын ажиллагааг хөгжүүлэх харилцан ашигтайгаар ажиллуулах асуудлыг хоёр орны холбогдох мэргэжлийн байгууллага, эрдэмтдийн санал, бодлогод тулгуурлан шийдвэрлэж, хэрэгжүүлэх;

Тавдугаарт, аялал жуулчлалын нэг гол цөм болсон, аялагчдын байнгын анхаарлыг татаж байдаг “Байгаль орчны дархан цаазтай газар”-ыг Шилийн гол аймаг, Дорноговь аймгийн бүс нутагт байгуулах; Дээрх “Байгаль орчны Дархан цаазтай газарт хоёр орны байгалийн ан амьтан, ургамлын нөөцийг бүрдүүлж хамгаалах, тэдгээрийг аялал жуулчлалын зорилгод ашиглах ажлыг зохион байгуулах;

Зургаадугаарт, Эрэн хот, Эрэн боомт болон хил залгаа орнуудын хооронд аялал жуулчлал, түүх соёлын дурсгалыг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, боомтын худалдаа арилжааны хүрээг өргөтгөх зэрэг асуудлуудаар Олон улсын “Төсөл”-т ажлыг зохион, хэрэгжүүлэх;

“Олон Улсын Форум”, “Эрдэм шинжилгээний хурал”, “Хоёр талын болон олон талын уулзалт” зохион байгуулах ажлыг хамтран уламжлал болгож, цар хүрээ үр дүнг нь сайжруулж ашиглах нь чухал юм гэсэн дүгнэлтийг хийж байна.

## Ашигласан материал

- БНХАУ-ын Засгийн газар. (2014). *БНХАУ-ын Засгийн газрын мэдээ*. Хөх хот
- БНХАУ-ын ӨМӨЗО. (2016). *Эрэн хотын Статистик тайлан*. Хөх хот
- Буриадын Улсын Их Сургууль. (2014). Бүс нутгийн аялал жуулчлалын хөгжлийн асуудал. *Олон Улсын эрдэм шинжилгээний Бага хурал*. Улан-Удэ
- Ван Чин Шин. (2008.9 сар). Эрэн хотын аялал жуулчлалын хөгжил. *Хот сэтгүүл*. Хөх хот
- Үнэн, Б. (2013). Өвөр Монголын аялал жуулчлалын хөгжлийн хандлага. *Хятад улсын Хойт орны Эдийн засгийн сэтгүүл, дугаар-3*. Хөх хот
- Үнэн, Б. (2010). Өвөрмонголын аялал жуулчлал. Хөх хот: Үндэсний хэвлэлийн Хороо